

**“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн  
2007 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ,  
үнэлгээ хийсэн дүн**

2008 оны 11 сарын 20

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын гүйцэтгэлд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн үр өгөөжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн Газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан “*Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам*”-ыг арга зүйн үндэс болгов.

Үнэлгээнд нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх, харьцуулан жиших, асуумж лавлагаа авах аргуудыг хэрэглэсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2006 оны хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан, хөтөлбөрийн хүрээнд 2004-2007 онд төслийн зээл авсан иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн хөрөнгийн ашиглалт, үр дүн, эргэн төлөлтийг шалгасан тухай УМХГ-ын ХАА-н Хяналтын Улсын Албаны тайлан, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуурт хамаарах статистик мэдээлэл зэрэг эх сурвалжуудыг ашиглав.

**ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр” Монгол Улсын Засгийн Газрын 2003 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 160 дугаар тогтоолоор батлагдан 2 үе шаттайгаар хэрэгжиж байна.

I үе шат–2003-2008 он: Эрчимжсэн мал аж ахуйг бүсийн тулгуур төвүүдийг түшиглэн байгуулахад дэмжлэг үзүүлэх;

II үе шат–2009-2015 он: Бүсийн тулгуур төвүүдийг түшиглэсэн эрчимжсэн мал аж ахуйг өргөжүүлэх, орон нутгийн хөгжлийн төвүүдийг түшиглэн хөгжүүлэх.

***Хөтөлбөрийн зорилго***

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх замаар олон улсын жишиг, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, импортыг бууруулах.

## **Хөтөлбөрийн зорилт**

1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулах
2. Эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх, загвар нэгж бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
3. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

## **Хөтөлбөр хэрэгжүүлснээр хүрэх үр дүн**

- Эрчимжсэн мал ахуйг эрхлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ.
- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадвар дээшлэнэ.
- Малын үүлдэрлэг байдал сайжирч, бүтээмж нэмэгдэж, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого, амьжиргааны түвшин дээшилнэ.
- Бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, суурин газрын хүн амын хүнсний хангамж дээшилнэ.

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2003-2006 ОНД ХИЙГДСЭН АЖЛЫН ТОЙМ**

<p>Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулж 2003-2004 онд 74.4 сая төгрөгийн санхүүжилт хийж байсан бол 2005 оноос санхүүжилтийн хэмжээг эрс нэмэгдүүлж 294.5 сая төгрөгийн, 2006 онд 289.5 сая төгрөгийн санхүүжилт хийжээ. Төсвөөс зарцуулсан нийт санхүүжилтийн хэмжээ 658.4 сая төгрөг байна.</p>
<p>- Өндөр ашиг шимтэй мал, амьтны үр, хөврөл үрийг НӨАТ-аас хөнгөлөх талаар “Татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгасан нь УИХ-д хэлэлцэгдэн баглагдсан.</p> <p>- “Фермерийн аж ахуйн тухай” хуулийн төсөл боловсруулсны зэрэгцээ эрчимжсэн МАА эрхэлж байгаа иргэн, ААН-д бэлчээр, хадлангийн газрыг эзэмшүүлэх, тэднээс авах бэлчээрийн төлбөрийн хэмжээг бага байлгах асуудлыг Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаж оруулсан.</p>
<p>- Герман, Хятад, Солонгос, Япон зэрэг улсуудад мал аж ахуйн чиглэлийн 18 мэргэжилтэн, фермер, аж ахуйн нэгжийн төлөөлөгчийг 14 хоногоос 3 сарын хугацаатай сургалтанд хамруулсан.</p> <p>- Улаанбаатар хот, СЭ, ТӨ, ӨВ, ХӨ, ХЭ, АР, БУ, ДА, ОР аймгуудад эрчимжсэн МАА эрхлэх ач холбогдолыг сурталчлах, мэргэжилтнүүдийн ур чадварыг нь дээшлүүлэх зорилгоор сургалт, уулзалт, семинар зохион байгуулж давхардсан тоогоор 890 хүнийг хамруулсан.</p>
<p>- Сүүний чиглэлийн ухны гүн хөлдөөсөн үрийг Куба Улсаас, сүүний чиглэлийн 60 үнээ, 10 бухыг Хятад улсаас, нарийн ноост Красноярк үүлдрийн 15 хуцыг ОХУ-аас импортоор авч сайжруулагчаар ашигласан.</p>
<p>- Сүү, махны чиглэлийн үхэр үржүүлдэг 45 иргэн, ААН-д 316.0 сая төгрөгийн, Гахайн аж ахуй эрхэлдэг 12 иргэн аж ахуйн нэгжид 47.0 сая төгрөгийн, Тахианы аж ахуй эрхэлдэг 5 иргэн, ААН-д 22.0 сая төгрөгийн, Францын тусламжийн байгуулагын хорооны шийдвэрээр 23 иргэн, ААН-д 84.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Импортоор оруулж ирсэн 190 эх зөгийг 9 аж ахуйн нэгж, иргэнд олгосон.</p>
<p>- Тэжээл тариалах, нэг ба олон наст ургамалын үр үржүүлэх, тариалах чиглэлээр төсөл боловсруулж ирүүлсэн 4 иргэн аж ахуйн нэгжид 14.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>- Швецарийн Засгийн газрын тусламжаар хэрэгжүүлж байгаа “Ногоон алт” төслийн хүрээнд бэлчээрийн олон наст ургамалын 2.5 тн үр импортлон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгож 16.0 мянган га талбайд тариалалт хийх боломжийг хангаж өгсөн</p>
<p>Япон улсын Засгийн газрын туслалцаатайгаар “Мал аж ахуй, газар тариалан хослосон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл”-ийг 2006 оноос эхлэн СЭ, БУ, ОР аймагт 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж эхлээд байна.</p>

## ТАВ. 2007 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Хөтөлбөрийн 2007 оны санхүүжилт, түүний хуваарилалт	
Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая.төг/
Цөм сүргийн үржлийн төвүүдийг бэхжүүлж, үржлийн ажлын байнгын үйлчилгээ бий болгох	250.0
Зохиомол хээтүүлгийн салбар бий болгон явуулын үйлчилгээ нэвтрүүлэх	153.0
Сүү, махны цэвэр үүлдрийн үхэр импортлон цөм сүргийн үржлийн төв болон зохиомол хээтүүлгийн салбаруудад олгож сайжруулагчаар ашиглуулах	240.0
Тэжээлийн олон наст ургамлын үр үйлдвэрлэх аж ахуйн нэгжийг буй болгох	41.8
Үхэр бордох талбай буй болгох	74.5
Хонь бордох талбай буй болгох	74.5
Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн бух, хуцны гүн хөлдөөсөн үр импортлон зохиомол хээтүүлгийн салбаруудад өгч сайжруулагчаар ашиглуулах	66.2
<b>Дүн</b>	<b>900.0</b>

Хөтөлбөрийн 2007 оны санхүүжилт, түүний зарцуулалт		
Дэмжигдсэн төслийн төрөл, ангилал	тоо	Олгосон зээл /сая.төг/
Олон наст тэжээлийн ургамал тариалах	2	32.0
Махны үхэр, хонины тэжээл үйлдвэрлэх	4	98.0
Уураг, энергийн агууламж өндөртэй тэжээл үйлдвэрлэх, тэжээлийн ургамал тариалж тэжээлийн нөөц бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	9	325.0
Бүрэн найрлагат эрдэс тэжээл үйлдвэрлэх	2	38.0
Махны чиглэлийн үхрийн үржлийн аж ахуй байгуулах	6	103.0
Махны чиглэлийн хонины аж ахуй байгуулах	6	54.0
Гахай үржүүлэх	6	23.0
Сүүний чиглэлийн Хартарлан үүлдрийн үхэр худалдан авах	15 гунж, 5 бух	42.0
Малын удмын сангийн үндэсний төв, цөм сүргийн үржлийн төвүүдэд үржлийн ажлын багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх	1	60.0
<b>Дүн</b>		<b>775.0</b>

### 1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	2007 онд хийгдсэн ажлууд
Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид бэлчээр, хадлангийн газрыг эзэмшүүлэх чиглэлээр Газрын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах	<i>“Газрын тухай хууль”-нд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан Засгийн газарт хэлэлцүүлж УИХ-д өргөн барьсан боловч шийдэгдээгүй.</i>
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдээс авах бэлчээрийн төлбөрийн хэмжээг бага байлгах талаар Газрын төлбөрийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл боловсруулах	<i>“Газрын тухай хууль”-нд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулан Засгийн газарт хэлэлцүүлж УИХ-д өргөн барьсан боловч шийдэгдээгүй.</i>
Фермерийн аж ахуйн эрх зүйн орчинг тодорхой болгох	<i>“Фермерийн аж ахуйн тухай хууль”-ийн төсөл боловсруулах ажлын хэсгийг УИХ-ын гишүүн А.Бакей, Ч.Содномцэрэн нараар ахлуулан яам, агентлаг, ЭШБ, ТББ-ын төлөөллийг оролцуулан байгуусан. Ажлын хэсэг 2007 оны 4-р сараас эхлэн ажилласан ба уг хуулийн төслийг эцэслэн боловсруулж УИХ-ын БОХХАА-н байнгын хороогоор 1 удаа хэлэлцүүлсэн. Гэвч УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд орж чадахгүй хойшлогдсоор байна.</i>

<p><i>Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа, тэдэнд үзүүлэх мэргэжлийн үйлчилгээнд шаардагдах үндэсний стандарт, холбогдох технологийн зөвлөмжүүдийг боловсруулах мэргэжлийн ажлын хэсгүүдийг 2007 оны 3 дугаар сард ТНБД-ын тушаалаар томилон ажиллуулж, холбогдох стандарт, технологийн зөвлөмжийн төслүүдийг Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлэн 2007 оны 11 дүгээр сард батлуулсан байна. Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Хурганы гулууз махны стандарт /MNS-1111-2007/</i></li> <li>- <i>Нядалгаанд орох хурганы жин, тарга хүчийг тодорхойлох техникийн шаардлага /MNS-1110-2007/</i></li> <li>- <i>Махны чиглэлийн өсвөр үхэр өсгөн бойжуулах, бордоход тавих шаардлага /MNS-5784-2007/</i></li> <li>- <i>Үйлдвэрийн аргаар тэжээл бэлтгэхэд тавигдах шаардлага /MNS-5796-2007/</i></li> <li>- <i>Малын удмын сангийн үндэсний төвийн стандарт /MNS-1157-2007/</i></li> <li>- <i>Цөм сүргийн үржлийн төвийн стандарт /MNS-1158-2007/</i></li> <li>- <i>Малын зохиомол хээлтүүлгийн салбарын стандарт /MNS-1159-2007/</i></li> </ul> <p><i>Мөн 3 технологийг боловсруулж, МААЭШХ-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулжээ.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>- <i>Махны чиглэлийн үхэр, хонины арчилгаа маллагааны технологи</i></li> <li>- <i>Өсвөр насны хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, шахаж бордох технологи</i></li> <li>- <i>Эрчимжсэн саалийн үхрийн аж ахуйн технологи</i></li> </ul>	
<p>Өндөр ашиг шимт мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үр, үржлийн ажил, үйлчилгээний зориулалтын багаж, тоног төхөөрөмжийг импортлоход нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татвараас чөлөөлөх асуудлыг судлан Татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар төсөл боловсруулах</p>	<p><i>Өндөр ашиг шимтэй мал, амьтны үр, хөврөл үрийг НӨАТ-аас хөнгөлөх талаар тодорхой заалтыг “Татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд туссан 2006 онд УИХ-д хэлэлцүүлж батлуулсан.</i></p> <p><i>Харин үржлийн ажил, үйлчилгээний зориулалтын багаж, тоног төхөөрөмжийг импортлоход НӨАТ болон гаалийн татвараас чөлөөлөх асуудлын хүрээнд хийгдсэн судалгаа, боловсруулсан баримт бичиг байхгүй байна.</i></p>
<p>Эрчимжсэн мал аж ахуй шинээр эрхлэгчдийг эхний 3 жилд орлогын албан татвараас чөлөөлөх асуудлыг судлах</p>	<p><i>Уг асуудлыг судлаж холбогдох тооцоо, үндэслэл гарган холбогдох хуулинд тусгуулах талаар өнгөрсөн онд ажиллаж эхэлсэн гэж тайлагнаж байсан боловч одоо болтол ямар нэг шийдэлд хүрч чадаагүй байна.</i></p>
<p>Бүсийн тулгуур төв болон аймаг, сум бүр эрчимжсэн аж ахуй эрхлэх нуггийг нарийвчлан тогтоож, хяналтандаа авах</p>	<p><i>Энэ асуудал Засгийн газрын 2003 оны 160 дугаар тогтоол, ХХАА-н сайдын 2006 оны 26 дугаар тушаалаар баталлагдан аймаг, сумын ИТХ-ын шийдвэрээр баталгаажсан гэж тайлагнажээ. Гэвч биднийг орон нутагт ажиллах хугацаанд тодорхой зураглал гаргаад хяналтандаа авчихсан аймаг, орон нутаг тааралдсангүй.</i></p> <p><i>УМХГ-аас хийсэн шалгалтаар энэ чиглэлээр хийсэн ажил аль ч аймагт байхгүй байгаа нь тогтоогдсон байна.</i></p>
<p>Сүү, махны чиглэлийн төрөлжсөн мал болон гахай, шувууны фермийн аж ахуй байгуулах төслийг сонгон шалгаруулж, тэргүүн ээлжинд дэмжлэг үзүүлэх</p>	<p><i>Махны чиглэлийн үржлийн аж ахуй байгуулах чиглэлээр 6 аж ахуйн нэгжид нийт 103.0 сая төгрөгийн, махны чиглэлийн хонины аж ахуй байгуулах чиглэлээр 6 аж ахуйн нэгжид 54.0 сая төгрөгийн зээл тус тус олгожээ.</i></p>
<p>Бүтээмж өндөртэй мал, амьтдыг үржлийн чиглэлээр өсгөн бойжуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид гадаад орон, байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	<p><i>НҮБ-ын ХХААБ-аас “Монгол орны төвийн бүсийн мах, сүүний эрчимжсэн аж ахуйн тэжээлийн нөөц, түүний үйлдвэрлэл хангамжийг нэмэгдүүлэх нь” техник тусалцааны төслийг БУ, СЭ, ТӨ аймгийн 7 сумын 24 аж ахуйн нэгж, фермерүүдийг хамруулан 400.0 мянган ам.долларт багтаан 2007 оны 11 сараас эхлэн 2 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэж үйл ажиллагаагаа эхлээд байна.</i></p>

Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх эрх зүйн орчинг сайжруулах талаар олон тооны ажлыг санаачлан зохион байгуулж өөрөөс хамаарах хэмжээнд хангалттай ажиллажээ. Харамсалтай нь нэгээс бусад хуулийн төслийг УИХ-аар батлуулж чадаагүй байна. Фермерийн аж ахуйн хөгжлийг дэмжих хамгийн чухал хүчин зүйл бол газар эзэмшлийн асуудал. Бэлчээр, тариалангийн газар баталгаажаагүй тохиолдолд фермерийн аж ахуйн хөгжилд ахиц дэвшил гарах ямар ч бололцоогүй юм. Иймээс энэ асуудлыг шийдвэрлэх зохистой хувилбарыг нэн даруй олох шаардлагатай болж байна.

Мөн эдийн засгийн орчинг сайжруулах талаар хэд хэдэн ажил санаачлан хэрэгжүүлсэн байна. Үүний үр дүнд татварын зарим хөнгөлөлтийн асуудал шийдвэрлэгджээ. Гэсэн хэдий ч эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтворжин санхүүгийн чадавхийн хувьд бэхжихэд шууд нөлөө үзүүлж байгаа эдийн засгийн таатай орчин бүрдсэн гэж дүгнэх боломжгүй байна. Эрчимжсэн аж ахуй шинээр эрхлэгчдэд арилжааны банкууд зээл олгох сонирхол багатай байгаа нь энэ салбар эрсдэлтэй, үйл ажиллагаа нь тогтворжиж чадаагүй байгааг нотолж байгаа юм.

Эрчимжсэн аж ахуй шинээр эрхлэх, аж ахуйгаа өргөтгөхөд дэмжлэг болохуйц эдийн засгийн таатай хүчин зүйл бол төрөөс үзүүлж байгаа хөнгөлөлттэй зээл, тусламж юм. 2007 онд ХХАА-н сайдын 61 дүгээр тушаалаар 180.0 сая төгрөгийн, 65 дугаар тушаалаар 148.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлжсэн байна. Харин зээл, тусламж авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэрхэн хянах, үр дүнг хэрхэн үнэлэх асуудалд Мал аж ахуйн хэлтэс огт анхаарлаа хандуулахгүй байна. Үүний улмаас иргэд, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааныхаа талаар эргэж мэдээллэх, үр дүнгээ тайлагнах талаар тогтож хэвшсэн ойлголтгүй явсаар байна. УМХГ-аас хийсэн шалгалтаар 130.0 сая төгрөгийн зээл авсан 31 иргэн, аж ахуйн нэгжийн хаяг тодорхойгүйн улмаас олдоогүй, 10 аж ахуйн нэгж зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, нийт зээлдэгчдийн 48.2 % нь зээлээ дутуу төлж барагдуулсан, 21.0 % нь огт төлж барагдуулаагүй зэрэг зөрчлүүд илэрчээ. Шалгалтаар илэрсэн нийт зөрчлийн 61.9 % нь зээлдүүлэгчтэй холбоотой байжээ. Энэ нь зээлийн үр ашгийг тооцох асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай болсныг харуулж байна.

**Нэгдүгээр зорилтын хүрээнд зохион байгуулсан ажлын хэрэгжилтийн үнэлгээ 85.0 % байна.**

## 2. Эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх, загвар нэгж бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	2007 онд хийгдсэн ажлууд
Сүү, махны чиглэлийн цэвэр болон эрлийз үхрийн эрчимжсэн аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулах	<i>Сүүний чиглэлийн үржлийн өсвөр үхэр нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт “Мон-таримал” ХХК шалгарч Хартарлан үүлдрийн 15 гунж, 5 бүхыг 42.0 сая төгрөгөөр худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэн өгсөн. Махны чиглэлийн Лимузин, Герефорд үүлдрийн бүхны үр худалдан авах тендер зарлан “Мон-таримал” ХХК-ийг шалгаруулан гэрээ хийж, худалдан авсан 2500 тун үрийг Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэн өгсөн.</i>
Мах-ноосны чиглэлийн цэвэр болон эрлийз хонины эрчимжсэн аж ахуйг газар тариалангийн бүс нутагт шинээр байгуулах, өргөтгөх бодлого баримтлах	<i>Нарийн, нарийвтар ноост хонины чанарыг сайжруулах зорилгоор арвин ашиг шимт хуцны үр импортлох тендер зарлан “Мон-таримал” ХХК-ийг шалгаруулан гэрээ хийж 5000 тун үрийг худалдан авч Малын удмын сангийн үндэсний төвд хүлээлгэн өгсөн.</i>
Гахай, шувууны аж ахуйг төвлөрсөн газруудыг түшиглэн хөгжүүлэх бодлого баримтлах	<i>Гахай үржүүлэх зорилгоор ирүүлсэн төслүүдэд сонгон шалгаруулалт хийж ХХАА-н сайдын 2007 оны 61 дүгээр тогтоолоор Мал хамгаалах сангаас 6 иргэн, аж ахуйн нэгжүүдэд 23.0 сая төгрөгний зээлийн дэмжлэг үзүүлсэн.</i>

Өмнөх жилүүдэд эрчимжсэн мал аж ахуйг дэмжин хөгжүүлэх бүс нутгийг тогтоон баталгаажуулсан бөгөөд энэ онд тэдгээрийг өргөжүүлэх бодлого барьж ажиллажээ. Гэвч хөтөлбөрийн үйл ажиллагааг олон аймаг, сумдад хүртээх бодлого баримталж ажилласан дутагдал ажиглагдаж байна. Үүний улмаас хаана үйл ажиллагаа явуулж байгаа, ямар аж ахуйн нэгжийг загвар аж ахуй болгон сонгосон нь тодорхойгүй болсон байна.

Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдсэн үзүүлэлтэй байгаа. Гэвч ямар шалгуур хангаж байгаа тохиолдолд эрчимжсэн аж ахуй гэж тооцох вэ гэдэг нь одоо хүртэл тодорхойгүй хэвээр байна. Энэ нь аймаг орон нутгаас судалгаа, үнэлгээнд ашиглах боломжгүй, үндэслэлгүй худал мэдээ ирүүлэх сөрөг үр дагаварыг үүсгэжээ. Жишээлбэл; Увс, Өвөрхангай, Орхон аймагт ажиллах хугацаандаа эрчимжсэн мал аж ахуйн талаар ХХААХҮЯ-нд ирүүлсэн мэдээллийг нь магадалж үзэхэд үндэслэл муутай мэдээлэл илгээсэн нь тогтоогдсон.

Энэ зорилтын хүрээнд дэмжлэг үзүүлэхээр төлөвлөгдсөн чиглэлүүдээс гахайн аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд мэдэгдэхүйц ахиц гарчээ. Гахайн фермийн аж ахуйн тоо нэмэгдсэний зэрэгцээ гахайн махны зах зээл дэх нийлүүлэлт 7 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

**Хоёрдугаар зорилтын хүрээнд зохион байгуулсан ажлын хэрэгжилтийн үнэлгээ 60.0 % байна.**

### 3.0 Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд

#### 3.1. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ	2007 онд хийгдсэн ажлууд
Эрчимжсэн МАА-н чиглэлээр гадаад оронд, мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах	<i>Солонгос улсын КОЙКА байгууллагын санхүүжилтээр 2007 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Гахайн аж ахуйн эрчимжсэн технологи, тэжээл үйлдвэрлэл” сэдэвт 21 хоногийн сургалтанд 16 хүнийг, 2007 оны 7 дугаар сард Солонгос улсын Ганвон мужид зохион байгуулсан “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл” сэдэвт 28 хоногийн сургалтанд 10 хүнийг яам, сургууль, ЭШБ, орон нутгийн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс сонгон оролцуулав.</i>
ХАА-н чиглэлийн их, дээд сургуулиудад эрчимжсэн аж ахуйн чиглэлээр мэргэжилтэн, бэлтгэх	<i>Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл, технологийн чиглэлээр ХААИС-ийн Биологийн нөөцийн менежменийн сургууль, Экологи, технологи, хөгжлийн сургууль, Агро-биологийн сургууль болон “Монгол фермер” дээд сургуулиас 52 мэргэжилтэн бэлтгэгдэн гарсан.</i>
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх ач холбогдлыг иргэдэд сурталчлах	<i>Монголын радиогийн МАЛЧИН нэвтрүүлэгтэй хамтран “Эрчимжсэн аргаар үхэр, хонины мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрийн хүрээнд махны чиглэлийн үхэр, хонины арчилгаа маллагааны технологийн чиглэлээр 12 удаагийн хичээл явуулсан. ЭШБ-ын судлаачид, ХААИС-ийн багш нарыг урьж оролцуулан “Эрчимжсэн аргаар хонь, үхрийн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга технологи, тэжээл бэлтгэл, малын арчилгаа маллагаатай холбоотой 5 сэдвээр нийт 36 цагийн радио хичээлийг Монголын радиогоор явуулсан.</i>
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон сонирхогчдоо зориулсан сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах	<i>ХААҮШҮОНТ-тэй хамтран Эрчимжсэн аргаар үхэр хонины мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх дэд хөтөлбөрийн сургагч багш бэлтгэх сургалтыг Улаанбаатар хот, БУ, ХЭ аймагт зохион байгуулсан.</i>

#### 3.2. Шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх, өндөр ашиг шимт мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үр гадаадаас авах, үржлийн материал солилцох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах

<b>Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ</b>	<b>2007 онд хийгдсэн ажлууд</b>
Цөм сүргийн малд зохиомол хээлтүүлэг хийх, үр, хөврөл үр шилжүүлэн суулгах зэргээр өсвөр мал бойжуулан борлуулах	2007 онд 20 аймгийн 52 суманд зохиомол хээлтүүлгийн 57 салбар ажиллаж нийт 109.0 мянган үнээ, эм хонь, эм ямаанд импортоор оруулж ирсэн өндөр ашиг шимтэй хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн.
Эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутагт олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгох	Үржлийн ажлын нэгжүүдийг багаж, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан ХХАА-н сайдын 84 дүгээр тушаалаар Малын удмын сангийн үндэсний төвд 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. Куба улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар 2007 онд сүүний чиглэлийн ямааны 5000 тун үрийг зохиомол хээлтүүлэг хийхэд шаардагдах багаж, тоног төхөөрөмжийн хамт импортоор оруулж ирсэн. Куба улсаас оруулж ирсэн сүүний чиглэлийн ухны гүн хөлдөөсөн үрээр ДА, БН, ӨВ, ТӨ, ДУ аймаг, Улаанбаатар хот дахь зохиомол хээлтүүлгийн 7 салбар Цөм сүргийн үржлийн төв болон малчдын хоршооны 614 ямаанд зохиомол хээлтүүлэг хийх үйлчилгээ хургэсэн.
Өндөр ашиг шимт малын үр, хөврөл үрийг малын генийн санд хадгалах	Мах, сүүний үхэр, махны чиглэлийн хонь, сүүний чиглэлийн ямааны үр нийт 20.0 мянган тунг импортоор авч генийн санд хадгалав.
Үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл, технологийн үзэсгэлэнг орон нутгийн болон улсын хэмжээнд зохион байгуулах	“Намрын ногоон өдрүүд 2007” нэгдсэн арга хэмжээний үеэр 16 аймаг, нийслэлийн 50 гаруй аж ахуйн нэгж, иргэдийн 195 толгой мал, амьтдыг хамруулан шилмэл малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж гойд ашиг шимт малаар 45 мал амьтдыг шалгаруулан шагнал олгосоноос гадна 2 аж ахуйн нэгжийг шилдэг үржлийн аж ахуйгаар шалгаруулан хадлан, тариалангийн зориулалттай дагалдах хэрэгсэл бүхий бага оврын трактороор шагнажээ.

2007 онд 20 аймгийн 52 суманд зохиомол хээлтүүлгийн 57 салбар ажиллаж нийт 109.0 мянган үнээ, эм хонь, эм ямаанд импортоор оруулж ирсэн өндөр ашиг шимтэй хээлтүүлэгч малын үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн гэж тайлагнасан байгаа. Гэтэл УМХГ-аас хийсэн шалгалтын тайланд Улаанбаатар хот болон ОР, БУ, ТӨ, ӨМ, ЧО аймгуудаас бусад аймгуудад өндөр ашиг шимтэй малын үрээр зохиомол хээлтүүлэг хийгээгүй гэж тэмдэглэгдсэн байна. Энэ нь хөтөлбөрийн тайланг шалгаж магадласан бодит мэдээлэл дээр тулгуурлан бичдэггүй болохыг нотлон харуулж байна.

Хөтөлбөрийн хүрээнд нийлүүлсэн багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байгаа тул орон нутагт үйл ажиллагаа явуулж буй нэгжүүдийн үржил, селекцийн үйлчилгээнд ахиц дэвшил гарч чадахгүй байгааг анхаарах шаардлагатай.

Малын генийн санд зөвхөн импортоор оруулж ирсэн өндөр ашиг шимт малын үрийг хадгалж байна. Иймээс нь уг үйл ажиллагааг цаашид тогтвортой үргэлжлэх бололцоог бүрдүүлэхийн тулд дотооддоо үр үйлдвэрлэх боломжийг бүрдүүлэх талаар илүү санаачлагатай ажиллах хэрэгтэй байна.

### 3.3. Малын төрөл, ашиг шимийн чиглэл, түвшинд тохирсон төгс чанарын тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлэх

<b>Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ</b>	<b>2007 онд хийгдсэн ажлууд</b>
Эрчимжсэн аж ахуйг технологийн зохистой хэмжээгээр эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардагдах эдлэн, бэлчээр, хадлангийн газрыг хууль тогтоомжид нийцүүлэн давуу эрхээр эзэмшүүлэх	13 аймгийн 96 суманд эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хадлангийн болон бэлчээрийн 160.0 мянган га газар нутгийг тодорхой хугацаагаар эзэмшүүлэхээр гэрээ хийх ажлыг орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран гүйцэтгэв.
Тэжээлийн зарим үйлдвэрийг сэргээх,	Уураг, энергийн агууламж өндөртэй тэжээл үйлдвэрлэх,

бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, дэвшилт техник, технологи нэвтрүүлэх	тэжээлийн ургамал тариалж тэжээлийн нөөц бүрдүүлэхэд нь зориулж ХЭ, БУ, ТӨ, СҮ, ЧО, ХӨ, АР, ӨВ, СЭ аймгаас тус бүр нэг төсөл шалгаруулан нийт 325.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
Өвс бэлтгэх хурдавчилсан технологи нэвтрүүлж өндөр нягтралтай боох, нийлэг уутанд дарш хийх, олон найрлагат хорголжин, багсармал тэжээл, макро, микро элементээр баяжуулсан эрдсийн шахмал, уураг-жуулсан, витаминжүүлсэн тэжээл үйлдвэрлэлийг дэмжих	Тэжээл бэлтгэх, хадлан хадах зориулалт бүхий жижиг оврын трактор, дагалдах техник хэрэгсэлийн үнийг 50 % хөнгөлөн 150 гаруй аж ахуйн нэгж, иргэдэд олгосон.

“Малын тэжээл хөтөлбөр” батлагдан хэрэгжиж эхэлснээр хөтөлбөрийн энэхүү зорилт хэрэгжиж тодорхой үр дүнд хүрэх таатай нөхцөл боломж бүрдсэн байна.

Тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд эрчимжсэн мал аж ахуйтай, Махны төрөлжсөн аж ахуй эрхлэгчид мах боловсруулах үйлдвэрлэгчтэй, Нарийн нарийвтар ноосны чиглэлийн аж ахуй эрхлэгчид нэхмэл, сүлжмэл үйлдвэрлэгчтэй, сүүний төрөлжсөн аж ахуй эрхлэгчид нь сүү боловсруулах үйлдвэрлэгчтэй хоршин ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн заалтын хүрээнд ямар нэг ажил хийгдээгүй байна. Дараагийн жилийн ажлын төлөвлөгөөнд энэ асуудлыг тусган зарим ажлуудыг эхлүүлэх хэрэгтэй.

Гуравдугаар зорилтын хүрээнд зохион байгуулсан ажлын хэрэгжилтийн үнэлгээ 75.0 % байна.

## ЗУРГАА. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

1. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас хөтөлбөрийн дагуу гаргасан эрх зүйн баримт бичгүүд, түүний хэрэгжилт	<p>- Өндөр ашиг шимтэй мал, амьтны үр, хөврөл үрийг НӨАТ-аас хөнгөлөх талаар “Татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгасан нь УИХ-д хэлэлцэгдэн батлагдсан.</p> <p>- “Фермерийн аж ахуйн тухай” хуулийн төсөл боловсруулсны зэрэгцээ эрчимжсэн МАА эрхэлж байгаа иргэн, ААН-д бэлчээр, хадлангийн газрыг эзэмшүүлэх, тэднээс авах бэлчээрийн төлбөрийн хэмжээг бага байлгах асуудлыг Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгаж УИХ-д өргөн барьсан боловч ишигдээдээгүй.</p> <p>- Мөн 7 стандарт, 3 технологийг боловсруулан зохих байгууллагуудаар батлуулан мөрдөж эхлээд байна.</p>
2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнесийн болон технологийн мэдлэг олгох чиглэлээр зохион байгуулсан сургалт, үзүүлэх сургууль, тэдгээрт хамрагдсан хүний тоо	<p>Сургалтанд хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгч, мэргэжилтнүүдийн нийт тоог гаргасан судалгаа байхгүй байна.</p> <p>2007 онд Солонгос улсын КОЙКА байгууллагын санхүүжилтээр зохион байгуулсан “Гахайн аж ахуйн эрчимжсэн технологи, тэжээл үйлдвэрлэл” сэдэвт 21 хоногийн сургалт болон Солонгос улсын Ганвон мужид зохион байгуулсан “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл” сэдэвт 28 хоногийн сургалтанд яам, сургууль, ЭШБ, орон нутгийн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл 26 хүн оролцон мэргэжил дээшлүүлсэн.</p>
3. Бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо байгуулагдсан загвар болон эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, шинээр бий болсон фермерүүдийн тооны өсөлт	<p>- Засгийн газрын 2002 оны 160 дугаар тогтоолоор “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хавсралтаар эрчимжсэн мал аж ахуй эрхлэх аймаг, сумыг тогтоож баталгаажуулсан.</p> <p>- одоогоор сүүний чиглэлийн үхрийн 494, Махны чиглэлийн үхрийн 10, Махноосны чиглэлийн хонины 13, Гахайн, Тахиа, Зөгийн 195 фермерийн аж ахуй үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Эрчимжсэн мал аж ахуйн шалгуур үзүүлэлт тодорхой болоогүй тул дээрх мэдээлэл баталгаатай үзүүлэлт болж чадахгүй байна.</p>

4. Улсын нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийн жин, нэгжээс авах ашиг шимийн өсөлт	<i>Цэвэр эрлийз малын тоо нэмэгдсэн хэдий ч нийт малд эзлэх хувийн жин нэмэгдээгүй байна. 2003 онд цэвэр, эрлийз малын эзлэх хувийн жин 6.5 % байсан бол 2007 онд энэ үзүүлэлт өөрчлөгдөөгүй байна. Энэ нь сүүлийн жилүүдэд нутгийн малын тоо эрс өссөнтэй холбоотой юм.</i>
5. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого болон амжиргааны түвшингийн өсөлт	<i>Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого болон амжиргааны түвшингийн өсөлтөд дүн шинжилгээ хийх, үр дүнг цаашидын үйл ажиллагаандаа тусгаж ажиллах талаар хөтөлбөр хэрэгжүүлэгчид хангалтгүй ажилласан тухай 2006 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд дурьдагдсан байгаа. ФАА эрхлэгчдийн тоо болон малагдаж байгаа мал, амьтдын тооноос өөр мэдээлэл байхгүй тул энэ шалгуур үзүүлэлтийн түвшинг тодорхойлох боломжгүй байна.</i>
6. Мах, сүү, өндөг зэрэг бүтээгдэхүүний өсөлт, махны экспорт болон мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хэмжээ	<i>Үхрийн мах, гахайн махны үйлдвэрлэл өссөн байна. Харин сүүний фермийн тоо ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн дүн байгаа хэдий ч үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээнд өөрчлөлт ороогүй байна. Үүний зэрэгцээ тараг, цоцгийн тосны үйлдвэрлэл хөтөлбөр хэрэгжиж эхлэх үеийнхээс буурчээ. Импортоор орж ирж буй мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хэмжээ буураагүйгээс гадна өндөг зэрэг зарим бүтээгдэхүүний импортын хэмжээ нэмэгдсэн байна.</i>
7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт, бууралт, хөрөнгө оруулалтын нийгмийн үр ашиг болон иргэдийн санал, гомдлын байдал	<i>Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулж 2003-2004 онд 74.4 сая төгрөгийн санхүүжилт хийж байсан бол 2005 онд 294.5 сая төгрөгийн, 2006 онд 289.5 сая төгрөгийн, 2007 онд 900.0 сая төгрөгийн санхүүжилт хийжээ. Үүнээс хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдсэн болох нь харагдаж байна. Харин зээл, тусламж авсан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хэрхэн хянах, үр дүнг хэрхэн үнэлэх асуудалд Мал аж ахуйн хэлтэс огт анхаарлаа хандуулахгүй байна. Үүний улмаас иргэд, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааныхаа талаар эргэж мэдээллэх, үр дүнгээ тайлагнах талаар тогтож хэвшсэн ойлголтгүй явсаар байна.</i>
8. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд газрыг урт хугацаагаар ашиглуулсан болон эзэмшүүлсэн байдал	<i>13 аймгийн 96 суманд эмчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдэд хадлангийн болон бэлчээрийн 160.0 мянган га газар нутгийг тодорхой хугацаагаар эзэмшүүлэхээр гэрээ хийх ажлыг орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудтай хамтран гүйцэтгэсэн</i>
9. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн гадаад орон, ОУБ-ын төслүүд, түүний үр нөлөө	<i>Япон улсын Засгийн газрын туслалцаатайгаар “Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл”-ийг 2006 оноос эхлэн СЭ, БУ, ОР аймагт 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна.</i>

## ДОЛОО. ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Зорилтууд	Үр дүнгийн үнэлгээ (%)
1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх эрх зүй, эдийн засгийн орчинг сайжруулах	85.0
2. Эрчимжсэн мал аж ахуйг бүсчилэн хөгжүүлэх, загвар нэгж бий болгож өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	60.0
3. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	75.0
<b>Дундаж үнэлгээ</b>	<b>73.3</b>

Тус хөтөлбөрийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж **73.3 %** байгаа тул “**ШААРДЛАГА ХАНГАЖ БАЙГАА**” гэж дүгнэж байна.

## **НАЙМ. ДҮГНЭЛТ**

1. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих эрх зүй, эдийн засгийн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд нэг хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэн батлуулсан, нэг хуулийн төсөл шинээр боловсруулж, 2 хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж тус тус УИХ-д өргөн барьсан, 7 стандарт, 3 технологийг боловсруулан зохих байгууллагуудаар батлуулан мөрдөж эхэлсэн зэргээр өөрөөс хамаарах хэмжээнд хангалттай олон тооны ажлыг санаачлан гүйцэтгэж зохих үр дүнд хүрчээ.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл 13 аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулагдаагүй төдийгүй хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дээр ч байгуулагдаагүй байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах ажилд ихээхэн хариуцлагагүй хандаж байгааг нотлон харуулж байна.

3. Эрчимжсэн аргаар аж ахуй эрхлэх сонирхол нэмэгдэж аж ахуйн нэгжийн тоо, цэвэр эрлийз малын тоо тогтвортой өсөж байгаа ч эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн орлого хэрхэн нэмэгдэж байгаа, үйл ажиллагааны үр ашиг ямар түвшинд байгаа, цаашид тогтвортой оршин тогтнох баталгаа хэр зэрэг байгаа талаар дүн шинжилгээ хийхгүй байна. Зарим хөрөнгө оруулалтын үр нөлөө мэдрэгдэж эхлэх хугацаа хараахан болоогүй байгаа ч урьдчилсан судалгаа заавал хийгдсэн байх шаардлагатай юм. Энэ талаар ТББ-уудтай хамтран ажиллах өргөн боломж байна.

4. Зохиомол хээлтүүлгийн явуулын үйлчилгээ үзүүлэх салбар нэгжийн тоо нэмэгдэж байгаа нь эрчимжсэн аж ахуйд маллагдаж байгаа малд өндөр ашиг шимт малын үрээр сайжруулалт хийх бололцоог хангаж өгсөн чухал ач холбогдолтой ажил болжээ. Гэсэн хэдий ч Улаанбаатар хот болон ОР, БУ, ТӨ, ӨМ, ЧО аймгуудаас бусад аймгуудад өндөр ашиг шимтэй малын үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажил хангалтгүй гүйцэтгэгдэж байна гэсэн хяналт шалгалтын дүн гарсан нь ажлын ахиц дэвшил гаргах шаардлагатай байгааг сануулж байна.

5. Бэлчээр, тариалангийн газар баталгаажаагүй тохиолдолд фермерийн аж ахуйн хөгжилд ахиц дэвшил гарах ямар ч бололцоогүй юм. Иймээс энэ асуудлыг шийдвэрлэх зохистой хувилбарыг нэн даруй олох шаардлага тулгарч байна.

## **ЕС. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

- Хөтөлбөр 4 дахь жилдээ хэрэгжээд эхний үе шат дуусах хугацаа ойртож байна. Гэтэл хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгүй явсаар өнөөдрийг хүрчээ. Энэ нь сэлүүргүй завиар далайд хөвж яваа аялагчтай зүйрлэж болохоор том дутагдал юм. Иймээс хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах зөвлөлийг хөтөлбөрийн 7.2.-т заасан ёсоор байгуулж, хийж гүйцэтгэх ажлаа жил бүр төлөвлөн, хэрэгжилтийг тухай бүрд нь хэлэлцэж дүгнэдэг болох шаардлагатай байна.
- Хөтөлбөрийн хүрээнд зээл авсан 31 иргэн, аж ахуйн нэгжийн хаяг тодорхойгүйн улмаас олдохгүй байгаа, 10 аж ахуйн нэгж зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, нийт зээлдэгчдийн 48.2 % нь зээлээ дутуу төлж барагдуулсан, 21.0 % нь огт төлж барагдуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн тухай дээр өгүүлсэн. Үүний

улмаас иргэд, аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааныхаа талаар эргэж мэдээллэх, үр дүнгээ тайлагнах талаар тогтож хэвшсэн ойлголтгүй явсаар байна. Энэ байдалд дүгнэлт хийж хөнгөлөлттэй зээлийг олгох, зээл авсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэлэх асуудлыг зохицуулах журам боловсруулан мөрдөж эхлэх хэрэгтэй юм.

- Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн мэдлэг, чадварыг дээшлүүлэн, фермерийн аж ахуйд технологийн дэвшил гаргах замаар тухайн аж ахуйд маллагдаж байгаа өндөр ашиг шимт малын эрүүл мэндийн хяналтыг төгөлдөржүүлж, хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж нөхцөлийг хангах талаар тодорхой ажлуудыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх хэрэгтэй.

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:

МХШҮГ-ын мэргэжилтэн

С.Дивангар

Танилцаж зөвшөөрсөн:

МХШҮГ-ын дарга

Д.Бат-Эрдэнэ